




АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР



ТӨМРИЙН ХҮДЭР ОЛБОРЛОЛТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭГИЙН ТӨЛӨВ

2013 он



Судалгааны ажлыг боловсруулсан :

АМГ, УУХ, НЭЗСТ-ийн дарга
АМГ, УУХ, НЭЗСТ -ийн ахлах мэргэжилтэн
АМГ, УУХ, НЭЗСТ-ийн мэргэжилтэн

Б.Бямбадагва
Ц.Цэгц
Ч.Навчаа

Судалгааны ажлын талаарх санал хүсэлтээ
дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
АМГ, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, АМГ-ын байр Уул уурхай хэлтэс, НЭЗСТ

Утас: 976-11-263709
Факс: 976-11-310041
E-mail: navchaa68@yahoo.com
Web page: <http://www.mram.gov.mn>



ГАРЧИГ

1. Дэлхийн төмрийн хүдрийн олборлолт ба нөөцийн байдал
2. Ирэх жилүүдэд шинээр ашиглалтанд орох төмрийн хүдрийн төслүүд ба өргөтгөлийн ажлууд (2012-2016)
3. Дэлхийн улс орнуудын төмрийн хүдрийн орд худалдан авалтын байдал
4. Төмрийн хүдрийн хэрэглээ
5. Төмрийн хүдрийн үнийн таамаглал
6. Монгол улсын төмрийн хүдэр олборлолтын хэмжээ ба нөөц
7. Монгол улсын төмрийн хүдрийн экспорт, олборлолт ААН-р
8. Стратегийн ордод хамаарах төмрийн хүдрийн ордууд
9. Жишиг үнийн эх сурвалжийн өөрчлөлт
10. Төмрийн хүдрийн үнийн одоогийн байдал ба цаашдын хандлага
11. Мэдээллийн эх сурвалж




1. ДЭЛХИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОЛБОРЛОЛТ БА НӨӨЦИЙН БАЙДАЛ, 2012 он


Төмрийн хүдрийн хэрэглээ нь дэлхийн гангийн үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаардаг ба 2008-09 оны санхүүгийн хямралын үед төмрийн хүдрийн хэрэглээ 8,5%-р буурч байсан бол 2010 онд 1,4 тэрбум тн-д хүрч 15%-р нэмэгдсэн. Дэлхийн гангийн холбооноос төмрийн хүдрийн хэрэглээ 2012 ба 2013 онд 4%-ийн өсөлттэй байна гэсэн тооцоо гаргасан байна. Төмрийн хүдэр олборлогч компаниуд нэмэгдэж буй төмрийн хүдрийн эрэлт хэрэглээг хангахын тулд сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүний хэмжээг жил бүр 10%-р нэмэгдүүлж байсан. 1-р зурагт 2002-2012 оны дэлхийн төмрийн хүдрийн бүтээгдэхүүн олборлолтын хэмжээ болон дундаж үнийг үзүүлээ.

1-р зураг

2010 оноос өмнө төмрийн хүдрийн үнийг жилийн гэрээгээр тохирч борлуулалт хийдэг байсан бол түүнээс хойш гол экспортлогч компаниуд болох BHP Billiton, Vale, ба Rio Tinto зэрэг компаниуд нь зах зээлийн эрэлт нийлүүлэлт дээр үндэслэн гэрээний үнийг улирлаар тохирч борлуулдаг болсон.



2-р зураг




Төмрийн хүдрийн зах зээлийн хэтийн төлөв, үргэлжилж буй Европын өрийн хямралыг үл харгалзан харьцангуй эерэг байна гэж ихэнх шинжээчид үзсэн. Хэрэв төмрийн хүдрийн бүтээгдэхүүнийг тогтсон цаг хугацаандаа нийлүүлсэн тохиолдолд шинэ төслүүд олноор эхэлж байгаатай уялдан зах зээл дээр төмрийн хүдрийн илүүдэл бий болох хандлагатай байна.

Гэвч сүүлийн үеийн McKinsey & Co-н судалгаагаар жил бүр ашиглаж байсан ордын нөөц дуусч хаагдахад ойролцоогоор 30 сая.тн төмрийн хүдрийн хомсдолд ордог ба ирэх 10 жилд одоогийн хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд 300 сая. тн төмрийн хүдрийг



шинэ төслөөр олборлох тооцоо гарсан байна. Дэлхийн төмрийн хүдрийн олборлолт болон нөөцийн хэмжээг 2,3-р зурагт үзүүлэв.

3-р зураг



4-р зураг болон 2-р хүснэгтэд үзүүлсний дагуу нийт төмрийн хүдрийн нөөцийн 72% буюу 1,38 тэрбум тн төмрийн хүдэр одоо идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 511 уурхайд байгаа ба өргөтгөл хийж буй уурхайнууд 6%, олборлолтын өмнөх шатандаа байгаа төслүүд нийт төмрийн хүдрийн нөөцийн 4%, ТЭЗҮ-ийн үедээ байгаа төсөл 10%, хайгуулын шатандаа байгаа төслүүд нийт нөөцийн 7%-г агуулж байна.

4-р зураг






1-р хүснэгт


Уурхайн үйл ажиллагааны үе шат дахь төмрийн хүдрийн нөөц				
Уурхайн үйл ажиллагааны байдал	Уурхайн тоо	Нийт нөөц (сая.тн)	Дундаж нөөц (сая.тн)	Нийт нөөцөөс эзлэх хувь
Олборлож буй уурхай	137	989,983.1	7,226.20	72%
Өргөтгөл хийж буй уурхай	43	88,655.8	2,061.80	6%
Олборлолтын өмнөх шатны уурхай	34	56,470.2	1,660.9	4%
ТЭЗҮ-ийн үе шат	81	140,975.3	1,740.40	10%
Хайгуулын үе шат	216	101,00.0	467.60	7%
Нийт/Дундаж	511	1,377,084.4	2.694.9	

2-р хүснэгт, 5-р зурагт үзүүлсэн USGS-ийн судалгаагаар БНХАУ нь 2012 онд дэлхийн төмрийн хүдрийн нийт бүтээгдэхүүний 43,7%-г олборлож төмрийн хүдрийн хамгийн том олборлогч хэвээрээ байна.

5-р зураг



Хэдийгээр БНХАУ-ын компаниуд олборлосон бүтээгдэхүүнийхээ талаар дэлгэрэнгүй тайлан ховор гаргадаг ч үндсэндээ олборлосон төмрийн хүдрийн бүтээгдэхүүнээ бүгдийг нь дотооддоо хэрэглэдэг. Дэлхийн төмрийн хүдрийн зах зээл дээр зөвхөн худалдан авагчийн байр сууринаас оролцдог ба төмрийн хүдрийн бүтээгдэхүүний далайн тээврийн худалдааны хувьд Австрали болон Бразил улсууд гол байр суурь эзэлдэг.



2-р хүснэгт

Төмрийн хүдрийн олборлолт, улсаар, 2006-2012 (Сая.тн)

Улс орнууд	2006	2007	2008	2009	2010	2011	2012
БНХАУ	588	600	824	880	1,070	1,330	1,300
Австрали	275	320	342	394	433	488	525
Бразил	318	360	355	300	370	373	375
Энэтхэг	140	160	220	245	230	240	245
Орос	102	110	100	92	101	100	100
Украйн	74	76	73	66	78	81	81
Өмнөд Африк	41	40	49	55	59	60	61
АНУ	53	52	54	27	50	55	53
Канад	34	33	31	32	37	34	40
Иран	20	20	32	33	28	28	28
Бусад	154	160	138	120	136	151	192
Нийт	1,799	1,931	2,218	2,244	2,592	2,940	3,000

Баруун Австралийн Fortescue's Pilbara комплекс дахь Christmas Creek уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлснээр 2009 онд Австрали улс нь төмрийн хүдэр олборлолтоороо Бразилийн өмнө гарч дэлхийд 2-р байранд орж эхэлсэн.

USGS мэдээлснээр 2012 онд Австрали улс 525 сая.тн төмрийн хүдэр олборлож дэлхийн төмрийн хүдрийн бүтээгдэхүүний хэмжээг 17,7%-р нэмэгдүүлсэн. Nullagine Уурхайд Fortescue (50%) ба BC Iron (50%) хамтран жилд 5 сая.тн бүтээгдэхүүн олборлох ажил, Extension Hill уурхайд Mount Gibson Iron компани жилд 3 сая. тн төмрийн хүдэр олборлох үйл ажиллагаа эхлүүлсэн ба энэ уурхайнууд бүгд баруун австралид байрладаг.

Бразил улс нь төмрийн хүдэр олборлолтоороо дэлхийд 3-т ордог ба 2012 онд 375 сая.тн төмрийн хүдэр олборлож дэлхийн төмрийн хүдрийн нийт бүтээгдэхүүний 12,6%-г олборлосон байна. 2011 онд жилд 8 сая.тн хүдэр олборлох хүчин чадалтай 2 уурхайн үйл ажиллагаагааг эхлүүлсэн ба ирэх 3 жилд нилээд том өргөтгөлийн ажил хийгдэж ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байна.

Дараагийн нилээд их хэмжээгээр төмрийн хүдэр олборлодог улсуудын дотор дэлхийн нийт бүтээгдэхүүний 8,2%-г эзэлдэг Энэтхэг (ихэнх үйлдвэрүүдийг засгийн газар нь хянадаг ба олборлосон бүтээгдэхүүний ихэнхийг дотооддоо хэрэглэдэг), 2012 онд 100 сая.тн олборлож дэлхийн нийт бүтээгдэхүүний 3,4%-г эзэлсэн Орос зэрэг улсууд багтаж байна. Дараагийн түвшний олборлогч улсуудад дэлхийн төмрийн хүдрийн нийт бүтээгдэхүүний 2,7% -г Украин, 2,1%-г Өмнөд Африк, 1,8%-г АНУ олборлож багтдаг юм байна.

Төмрийн хүдрийн өндөр үнэ болон нэмэгдэж байгаа эрэлт хэрэглээнээс шалтгаалан төмрийн хүдэр олборлогчид 2009 оны эдийн засгийн уналтаас хойш олборлолтоо нэмэгдүүлж эхэлсэн. 2011 онд төмрийн хүдрийн 14 том уурхайн 10 нь бүтээгдэхүүнийхээ хэмжээг 4%-р буюу 35,7 сая.тн-р нэмэгдүүлсэн байна. Vale, Rio Tinto, BHP Billiton гэсэн 3 том олборлогч компани сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүний хэмжээг 5%-р буюу нийлээд 648,8 сая.тн-р нэмэгдүүлсэн.

Vale компани нь дэлхийн хамгийн том төмрийн хүдрийн олборлогч компани



бөгөөд Бразилийн төмрийн хүдрийн бүтээгдэхүүний 75%-г нийлүүлдэг ба бүтээгдэхүүний хэмжээгээ сүүлийн жилүүдэд нэмэгдүүлсээр байна.

Дэлхийн 2 дахь том төмрийн хүдэр олборлогч Rio Tinto компани нь 2010 онд 184,6 сая.тн хүдэр олборлож байсан бол 2011 онд 4%-р нэмэгдүүлж 191,8 сая.тн төмрийн хүдэр олборлосон. Rio Tinto компанийн Канадын салбар компани болох Iron Ore Co of Canada нь (Mitsubishi Corp 26%, Орон нутгийн компани 15% эзэмшдэг) 2013 он гэхэд жилд 26 сая.тн-оор нэмэгдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Rio Tinto компани нь газар зүйн байдлаараа өөр газарт буюу Австрали болон Гвиней дахь Simandou уурхайн бүтээгдэхүүн олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Жилд 100 сая.тн-оос илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өөр компани бол BHP Billiton бөгөөд 2011 онд Австрали болон Бразил дахь уурхайгаасаа 134,4 сая.тн төмрийн хүдэр олборлож бүтээгдэхүүний хэмжээгээ 8%-р нэмэгдүүлсэн. Дээр дурдсан 3 том олборлогч компаниуд нь 2012-2013 онуудад төмрийн хүдэр олборлох хэмжээгээ улам нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

2. 2012-2016 онуудад шинээр хэрэгжүүлж эхлэх төмрийн хүдрийн төслүүд ба өргөтгөлийн ажил хийгдэх уурхайнууд


6-р зураг

Төмрийн хүдэр олборлогчид 2012 онд 32 шинэ уурхай ба өргөтгөлийн ажлын төслүүд хэрэгжүүлж 2012 онд 144 сая.тн, 2013 онд 327 сая.тн, 2014 онд 287 сая.тн, 2015 онд 6 сая.тн, 2016 онд 90 сая.тн нийтдээ 855 сая.тн төмрийн хүдэр ирэх жилүүдэд нэмж олборлохоор төлөвлөсөнийг 6-р зураг болон 3-р хүснэгтэд үзүүлээ.



3-р хүснэгт

Шинээр ашиглалтанд орох төмрийн хүдрийн төслүүд, 2012-2016						
Жил	Өргөтгөлийн ажлын тоо	Шинэ уурхайн тоо	Нийт шинэ төсөл	Нөөц (сая.тн)	Нийт зардал (сая.доллар)	Нэмж олборлох хэмжээ (сая.тн)
2012	12	20	32	43,095.8	19,049.8	144.2
2013	15	9	24	45,057.2	31,189.0	327.4
2014	13	3	16	49,063.4	36,594.0	287.0
2015	1	1	2	370.0	1,158.7	5.9
2016	0	1	1	4,239.6	19,500.0	90.0
Нийт	41	34	75	141,199.4	107,491.6	854.4




7-р зураг

Ирэх жилүүдэд ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа зарим том төслүүдийн тухай товч мэдээллийг дараагийн хэсэгт авч үзсэн.

Австрали улс нь ирэх жилүүдэд дэлхийн төмрийн хүдрийн олборлолт дахь өөрсдийн хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд 15 шинэ уурхай болон өргөтгөлийн ажлаас жилд 307 сая.тн төмрийн хүдэр нэмж олборлох төлөвлөгөөтэй байгааг 7-р зураг, 4-р хүснэгтэд үзүүлэв.

Баруун Австрали дахь Sino-Iron, Karara ба бусад 5 төслөөс 2012 онд нийтдээ 47 сая.тн төмрийн хүдэр, 2013 онд 6 уурхайгаас жилд 184 сая.тн, 2014 онд 2 уурхайгаас нийтдээ 76 сая.тн төмрийн хүдэр нэмж олборлохоор төлөвлөсөн. Бразил улс нь ирэх 5 жилд 5 шинэ уурхай ба 11 өргөтгөлийн ажил хийхээр төлөвлөсөн нь шинээр төмрийн хүдэр олборлох төсөл хэрэгжүүлж буй орнуудаас 2-р байранд орж байгаа бөгөөд нийтдээ 295,3 сая.тн төмрийн хүдэр нэмж олборлохоор төлөвлөсөн.

Шинээр олборлох төмрийн хүдрийн хувь хэмжээ, улсаар, 2012-2016 он



4-р хүснэгт

Олборлолтын өмнөх шатандаа байгаа төслүүд, улсаар					
Улс	Ордын тоо	Нийт нөөц (сая.тн)	Зардал (сая. доллар)	Олборлох хэмжээ / 2011-2016 (сая.тн/ жил)	Хувь хэмжээ
Австрали	15	40,470.2	34,725.6	306.6	35%
Бразил	16	33,781.0	47,64.5	295.3	34%
Энэтхэг	6	1,685.9	626.2	45.8	5%
Канад	5	6,095.5	3,762.6	41.3	5%
Орос	5	4,029.4	2,918.7	41.0	5%
Сиера Леон	2	13,829.0	3,091.0	33.2	4%
Хятад	6	1,778.3	1,391.5	30.2	3%
Чили	5	1,406.0	973.9	25.8	3%
Гвиней	2	26,500.0	1,585.0	19	2%
АНУ	4	2,267.5	1,879.0	8.7	1%
Казакстан	1	4,423.8	1,280.0	7	1%
Украин	2	4,585.0	2,520.8	4.9	1%
Швед	1	224.3	807.0	4.4	1%
Бусад	7	4,050.0	5,284.5	17.10	2%
Нийт	77	145,126.0	108,610.3	880.3	



Энэтхэг улс нь ирэх 2 жилд төмрийн хүдрийн нийт бүтээгдэхүүнээ жилд 45,8 сая. тн-оор нэмэхээр төлөвлөснөө мэдээлсэн байна. 2012 онд 2 шинэ уурхайгаас жилд 14,4 сая.тн, 2 шинэ өргөтгөлөөр 9,2 сая.тн, 2013 онд 2 өргөтгөлийн ажил дуусгаж нийтдээ жилд 22,2 сая.тн төмрийн хүдэр олборлох төлөвлөгөөтэй байна гэж мэдээлсэн.

Энэ хугацаанд төмрийн хүдэр олборлох хүчин чадлаа жилд 45 сая.тн-оос илүү нэмэгдүүлэх өөр улс орон байхгүй байгаа бөгөөд ирэх 5 жилд Орос болон Канадад үйл ажиллагаагаа эхлүүлэх 10 шинэ төсөл хугацаандаа эхэлбэл жилд 82,3 сая.тн төмрийн хүдэр жилд олборлохоор төлөвлөсөн байна.

5-р хүснэгтэд үзүүлсний дагуу 2012 онд төмрийн хүдрийн 32 төсөл хэрэгжиж бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн. Эдгээрээс 12 уурхайд өргөтгөлийн ажил хийгдэж жилд 33,4 сая.тн төмрийн хүдэр, 20 шинэ уурхай ажиллаж эхэлснээр жилд 110,9 сая.тн төмрийн хүдэр нэмж олборлохоор төлөвлөсөн. Шинэ уурхайнууд дээр 2012 онд төмрийн хүдэр боловсруулах 5 том тоног төхөөрөмжийг суурилуулна. Хамгийн том өргөтгөлийн ажлыг нь Энэтхэгийн National Mineral Development-ийн Chhattisgarh Group хийх ба энэ уурхай 2011 онд 25 сая.тн төмрийн хүдэр олборлосон ба 2012 оноос Bailadila 11/B орд дээр өргөтгөлийн ажил хийгдсэнээр олборлох хүчин чадлаа жилд 7 саяар нэмэгдүүлнэ.

5-р хүснэгт

2012 онд эхэлсэн олборлолтын өмнөх шатны төслүүд ба өргөтгөлийн ажил					
Эзэмшигч	Байрлал	Байдал	Нөөц (сая. тн)	Зардал (сая. доллар)	Олборлох хэмжээ (сая.тн/ жилд)
Citic Pacific 80%, China Metallurgical 20%	Австрали	Олборлолтын өмнөх шат	2,185.0	6,000.0	24.0
Vale 51%, BSG Resources 49%	Гвиней	Олборлолтын өмнөх шат	26,500.0	1,260.0	15.0
Steel Authority of India	Энэтхэг	Олборлолтын өмнөх шат	511.0		14.0
Minera Monte Grande	Чили	Олборлолтын өмнөх шат	500.0	45.0	12.0
Gindalbie Metals 50%, Anshan Iron and Steel 50%	Австрали	Олборлолтын өмнөх шат	2,473.9	2,584.0	10.0
National Mineral Development	Энэтхэг	Өргөтгөл	800.9	126.2	7.0
Evrz Group	Орос	Өргөтгөл	3.5		6.0
Jangsu Huitai	Чили	Олборлолтын өмнөх шат		7.7	4.8
ESSAR Group	АНУ	Олборлолтын өмнөх шат	1,880.1	1,600.0	4.1
Tata Steel 80%, New Millenium Iron 20%	Канад	Олборлолтын өмнөх шат		325.0	4.0
Bellzone Mining 50%, China International Fund 50%	Гвиней	Олборлолтын өмнөх шат	74.4	334.7	4.0
Mineral Resources	Австрали	Олборлолтын өмнөх шат	41.5		4.0
OneSteel	Австрали	Олборлолтын өмнөх шат	18.2	137.5	3.6
China Investment 33%, Өөр эзэмшигч 67%	Монгол улс	Өргөтгөл			3.5
Usinas Siderurgicas 70%, Sumitomo Corp 30%	Бразил	Олборлолтын өмнөх шат		2,210.0	3.0
Ferrexpo	Украин	Өргөтгөл	3,589.0	20.8	3.0
16 жижиг орд			4,518.3	4,399	21.7
Нийт			43,095.8	19,049.8	144.2




Баруун Австрали дахь Sino-Iron (Citic Pacific 80%, China Metallurgical 20%) хамтарсан үйлдвэр нь жилд 24 сая.тн төмрийн хүдэр нэмж олборлох гэж байгаа нь олборлолтын хэмжээгээ нэмэгдүүлж байгаа уурхайнуудаас нилээд дээгүүр орж байна. 2012 оны 1-р сарын байдлаар China Metallurgical компани нь олборлох үйл ажиллагаагаа 2012 оны 8 сараас эхлэхээр төлөвлөсөн ба зардал нь нэмэгдэж 6 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Vale компани нь Африкийн Guinea-н Simandou уурхайн (Vale 51% BSG Resources 49%) олборлолтыг жилд 15 сая.тн-д хүргэхээр өргөтгөлийн ажил хийж байна. Зардал нь нийтдээ 1,26 тэрбум ам.доллар болох ба 2012 онд 380 сая ам.доллар зарцуулсан тооцоо гарсан байна. 2012 оны 5 сард African Iron Ore групп Guinea-н засгийн газартай хамтарсан үйлдвэр байгуулсан ба Societe Guineenne du Patrimoine Minier компани нь Simandou уурхайн өмнөд хэсэгт баригдах барилга, төмөр зам, боомт зэрэг дэд бүтцийн санхүүжилтийг хийхээр болсон байна.

Өөр гурван шинэ уурхай ашиглалтанд орсноор жилд 10 сая.тн ба түүнээс илүү төмрийн хүдэр нэмж олборлохоор төлөвлөсөн байна. Энэтхэгийн Төмөрлөгийн асуудал эрхлэх газраас Chhattisgarh дахь жилд 14 сая.тн төмрийн хүдэр олборлох Rowghat төмрийн хүдрийн уурхайн төслийг хувийн компаниар гүйцэтгүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа зарласан.

Чили улсад 2012 оны 1-р сард Minera Monte Grande -ийн 45 сая долларын зардлаар хийж гүйцэтгэсэн Hermotita уурхайн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлийн үнэлгээ батлагдсан байна. Энэ уурхай 50 жилийн хугацаанд жилд 26 сая.тн хүдэр боловсруулж жилд 12 сая.тн төмрийн хүдрийн баяжмал гаргана. Барилгын ажил нь 2012 онд эхлэх ба 5 сарын хугацаанд дуусгах төлөвлөгөөтэй байна. Дараагийн том төсөлд Баруун Австралийн Karara уурхайн төсөл орж байна. Энэ төслийн 50% -г Gindalbie Metals компани, 50% Anshan Iron and Steel компани эзэмшиж байна. Gindalbie компани нь саяхан цахилгаан хангамж авахын тулд Western Power компанитай гэрээ байгуулсан ба ордын өмнөд ба зүүн хэсэгт бүрэн хэмжээний хөрс хуулалт 2012 оны эхээр эхэлсэн байна. Уурхайн ихэнх ажил 2012 оны 6 сар гэхэд дуусах ба магнетитийн баяжмалын тээвэрлэлт 2012 оны 9 сараас эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

8-р зураг





8-р зураг, 6-р хүснэгтэд үзүүлснээр нөөц тогтоох болон ТЭЗҮ-ийн шатанд нийт 297 төмрийн хүдрийн төсөл хэрэгжиж байгаа бөгөөд нөөцийн хэмжээ болон төмрийн хүдрийн агуулга бүгд эцэслэн тогтоогдоогүй байна. Бүс нутгаар нь авч үзвэл Латин Америкт хэрэгжих 52 төсөлд 77,8 тэрбум.тн төмрийн хүдэр агуулагдаж байгаа ба нийт нөөцийн 52%-ийг эзэлж байна.

6-р хүснэгт

Олборлох шатандаа байгаа төмрийн хүдрийн төслүүд, байрлалаар (Нийт нөөцөөр)							
Байрлал	Хайгуулын шатны төсөл	ТЭЗҮ-ийн шатны төслүүд	Нийт төслийн тоо	Хайгуулын шатны төслийн нөөц /сая.тн/	ТЭЗҮ-ийн шатны төслийн нөөц /сая.тн/	Нийт нөөц (сая.тн)	Эзлэх хувь хэмжээ
Латин Америк	33	19	52	22,078.5	55,676.1	77,754.7	32%
Хойд Америк	20	8	28	17,334.9	34,511.4	51,846.3	21%
Австрали	82	28	110	28,988.7	20,661.7	49,650.4	21%
Африк	32	9	41	20,764.5	16,096.9	36,861.4	15%
Хуучин ЗХУ	18	5	23	7,125.7	10,490.9	17,616.5	7%
Ази	14	4	18	2,855.0	738.7	3,593.8	1%
Европ ба дорно дахин	8	6	14	1,176.7	1,949.2	3,125.9	1%
Номхон далайн арлын улсууд	9	2	11	675.9	850.4	1,526.3	1%

Эдгээр төслөөс хамгийн том нь Jindal Steel компаний Bolivia дахь El Mutun төсөл бөгөөд 20 тэрбум тн төмрийн хүдэр агуулж байна. 2012 оны 6 сард Jindal компани нь хэрвээ Bolivia-ийн засгийн газар El Mutun төсөлтэй холбоотой хүлээж буй үүрэг болон байгалийн хий нийлүүлэх гэрээгээ биелүүлээгүй тохиолдолд хөрөнгө оруулалтаа зогсоохоо зарласан байна. 2011 онд Jindal Steel компани нь нийт 2,1 тэрбум долларын өртөгтэй жилд 10 сая. тн хорголжин төмрийн хүдэр боловсруулах үйлдвэр, жилд 6 сая.тн цэврүүтэй төмөр гаргах үйлдвэр, жилд 1,7 сая.тн ган боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөж байсан ч улс төрчдөөс шалтгаалан зогсонги байдалд орсон байна.

Латин Америк дахь дараагийн том төсөл нь Бразил дахь IMS Mineracao-ийн Juina project төсөл бөгөөд 40,5% Fe агуулгатай 5,29 тэрбум тн нөөцтэй нь тогтоогдсон. ТЭЗҮ-ийн судалгааны ажил нь 2013 оны 6 сард хийгдэж дуусна.

Чилийн Atacama дахь Chile Yilong төсөл (Shunde Rixin компани 70%, China Minmetals 30%) хэрэгжиж эхэлснээр 5 тэрбум.тн нөөцтэй энэ ордоос БНХАУ-руу жилд 3 сая.тн төмрийн хүдрийг China Minmetals компаниар дамжуулан БНХАУ-ын төмөр болон гангийн үйлдвэрүүдэд нийлүүлэхээр төлөвлөсөн байна. Олборлох шатандаа байгаа төмрийн хүдрийн төслийн 21% (51.8 тэрбум.тн нөөц) Хойд Америкт байна. Хамгийн том нь Quebec дахь (Wuhan Iron 60%, Adriana Resources 40%) Lac Otelnuk хамтарсан үйлдвэрийн төсөл бөгөөд 29,7% агуулгатай 23,7 тэрбум.тн нөөцтэй. Уурхайн төлөвлөлтийг хийх зорилгоор анхан шатны ерөмдлөгийн ажлууд хийгдэж эхэлсэн ба ТЭЗҮ боловсруулах ажил нь хийгдэж байна. Adriana ба Wuhan (WISCO) компаниуд Lac Otelnuk төсөл дээр хамтарсан үйлдвэр байгуулсан ба WISCO нь төслийн 70%ийг санхүүжүүлэхийн тулд 91



сая долларын нэмэлт санхүүжилт хийхээр болсон.

Австрали улс олборлолтын өмнөх шатандаа байгаа 110 төслийг цаашид хэрэгжүүлэх ба нийт төмрийн хүдрийн нөөцийн 21% (49.7 тэрбум.тн нөөцтэй) нь агуулагдаж байна. Төслүүдийн нөөцийн дундаж хэмжээ нь 451,8 сая.тн ба бусад бүс нутгуудад дундаж хэмжээнээс доогуур нөөцтэй төслүүд нилээд байна. Хамгийн том нь төсөл нь Resourcehouse-ийн бүрэн эзэмшил болох Баруун Австрали дахь China First Iron Ore төсөл бөгөөд 3,5 тэрбум тн хүдрийн нөөцтэй. 2011 оны 5 сарын байдлаар Resourcehouse нь Hong Kong-ийн хөрөнгийн бирж дээр 3,42 тэрбум ам.доллар босгохын тулд нэгж хувьцаа нь 0,58-0,63 ам.долларын үнэтэй 5,7 тэрбум хувьцаа борлуулахаар төлөвлөсөн. Энэ орлогоосоо 700 сая долларыг энэ төслийг хэрэгжүүлэхэд ашиглахаар төлөвлөсөн.

Африкт цаашид олборлох нийт нөөцийн 15% буюу 36,9 тэрбум тн төмрийн хүдрийн нөөц байна. Bellzone Mining компанийн эзэмшил Kalia төсөл нь ТЭЗҮ боловсруулах шатандаа байгаа ба 6,5 тэрбум тн хүдрийн нөөцтэй. 2012 оны 6-р сард Bellzone компани нь 35,8 % Fe агуулгатай суперген BIF (Banded Iron Formations) төрлийн батлагдсан нөөц 413,9 сая.тн байна гэж шинэчлэн зарласан. Туршилтын ажлын үр дүнд BIF (Banded Iron Formations) төрлийн хүдрийн нөөцөөс 59,3% агуулгатай төмрийн хүдрийн баяжмал 151 сая.тн-г үйлдвэрлэх боломжтойг нотолсон байна.

Congo дахь Zanaga орд дээр 2011 оны 10 сард (Xstrata's 50%, Zanaga Iron 50%) анхны ТЭЗҮ-ийн ажил хийгдэж эдийн засгийн боломжит хувилбарыг баталсан. Үүнд жилд 45 сая.тн төмрийн хүдрийг төмөр замаар зөөх ба зардал нь 7,5 тэрбум доллар болно. Хуучин ЗХУ-д харьяалагдаж байсан орнуудад эхлэх шатандаа байгаа нийт төмрийн хүдрийн төслийн 7% буюу 23 төсөл байгаа ба нийт нөөц нь 17,6 тэрбум.тн байна. ОХУ дахь хамгийн том төсөл нь Timir Cluster орд бөгөөд Evraz Group 51%, Alrosa компани 49%-г эзэмшдэг. Одоогоор үйл ажиллагаа нь ТЭЗҮ боловсруулах шатандаа байна. Хоёр дахь том төсөл нь Украин дахь Kuksungurskoye төсөл бөгөөд Ilyich Metallurgical компани 50%, Zaporizhstal компани 50%-г нь эзэмшиж байна. Азид 18 төсөл хэрэгжих бөгөөд нийт нөөц нь 3,6 тэрбум тн байна.

3.ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРД ХУДАЛДАН АВАЛТЫН БАЙДАЛ, 2011 ОНЫ 11 САР ХҮРТЭЛХ МЭДЭЭЛЭЛ

Төмрийн хүдрийн зах зээл сэргэж эхэлснээр дэлхийн дахинаа төмрийн хүдрийн орд худалдан авалт сүүлийн жилүүдэд нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 9,10,11-р зураг болон 7,8,9-р хүснэгтэд төмрийн хүдрийн орд газрын орд худалдан авалтыг улс болон бүс нутгаар үзүүллээ. Ашигт малтмалын орд худалдан авалтын байдалд дүгнэлт хийж үзэхэд төмрийн хүдрийн ордын худалдан авалт бусад ашигт

9-р зураг






малтмалын ордтой харьцуулахад хамгийн өндөр байгаа нь төмрийн хүдрийн хэрэглээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгааг нотолж байгаа бөгөөд БНХАУ нь төмрийн хүдрийн орд хамгийн ихээр худалдаж авсан үзүүлэлттэй байна.

7-р хүснэгт

Төмрийн хүдрийн ордын худалдан авалт, улсаар, 2010.01-2011.10				
Худалдан авагч улс	Хийгдсэн гэрээний тоо	Төлсөн үнэ. (сая.доллар)	Төмрийн хүдрийн нөөц (сая.тн)	Нийт үнэд эзлэх хувь
БНХАУ	31	11,308.7	14,954.4	41%
АНУ	2	4,740.6	864.8	17%
Бразил	4	3,148.8	201.6	11%
Япон	2	2,438.5	1,828.8	9%
Англи	12	2,320.7	3,155.2	8%
Австрали	25	2,307.1	1,758.1	8%
Энэтхэг	4	1,127.8	2,082.1	4%
Бусад	5	290.8	470.6	1%
Нийт	85	27,682.9	25315.7	

10-р зураг




8-р хүснэгт

Төмрийн хүдрийн ордын худалдан авалт, бүс нутгаар, 2010.01-2011.10				
Бүс нутаг	Худалдан авалтын тоо	Төлсөн үнэ. (сая.доллар)	Олборлох төмрийн хүдэр (сая.тн)	Нийт төлсөн үнэд эзлэх хувь
Африк	21	12,478.8	13,211.1	45.1%
Латин Америк	18	6,697.3	3,854.7	24.2%
Хойд Америк	10	5,628.1	5,632.1	20.3%
Австрали	24	2,191.6	2,421.9	7.9%
Ази	7	333.1	34.6	1.2%
Европ	2	199.0	140.6	0.7%
Ном/далайн бүс нутаг	3	155.0	20.6	0.6%
Нийт	85	27,682.9	25,315.7	



11-р зураг




БНХАУ-ын ашигт малтмалын төсөл худалдан авалтын байдал, 2004-2010

9-р хүснэгт.

	Ашигт малтмалын нэр	Үнэ/тэрбум доллар	Эзлэх %
1	Төмрийн хүдэр	952.1	70%
2	Зэс	249.4	18%
3	Цайр	64.3	5%
4	Алт	10.7	1%
5	Никель	51	4%
6	Бусад	29	2%

12-р зураг





4. ТӨМРИЙН ХҮДРИЙН ИМПОРТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТИЙН ТААМАГЛАЛ 2012-2017

Төмрийн хүдрийн импортын хувьд: 2017 он хүртэл хэрэглээ нь яаж өсөх таамаглалыг дараахь хүснэгтэд үзүүллээ.

БНХАУ-ын төмрийн хүдрийн хэрэглээ 2013 онд 50 сая тн-р нэмэгдэнэ гэж тооцож байгаа бөгөөд энэ нь төмрийн хүдрийн нийлүүлэлтийн илүүдлийг бүгдийг нь шингээж чадахгүй гэж үзэж байна. БНХАУ-ын төмрийн хүдрийн дотоодын нийлүүлэлт 20 сая. тн-р нэмэгдэх ба дэлхийн төмрийн хүдрийн топ 3 олборлогч компаниуд нийтдээ 100 сая. тн төмрийн хүдэр нэмж олборлох төлөвлөгөөтэй байна. 2012 онд БНХАУ нь нийтдээ 743,55 сая.тн төмрийн хүдэр импортлосон ба үүнийг урьд оны хэмжээтэй харьцуулахад 8,4%-р нэмэгдсэн. Гэвч эдийн засгийн удаашралтай байдлаас шалтгаалан нийт гангийн бүтээгдэхүүний хэмжээ 716,5 сая.тн болж зөвхөн 3,1%-р өссөн үзүүлэлттэй байна. 2013 онд БНХАУ нь 1,14 тэрбум.тн төмрийн хүдэр хэрэглэх ба үүнээс 770 сая.тн төмрийн хүдрийг импортлоно гэж БНХАУ-ын Ган ба Төмөрлөгийн Холбооноос мэдээлсэн.

10-р хүснэгт

Улс	2017 он/сая тн/жилд
БНХАУ	999
Япон	149
БНСУ	74
Баруун Европ	138
Бусад Азийн улс	61
Тайвань	23
Бусад ойрхи дорнод/улс	35




5. ТӨМРИЙН ХҮДРИЙН ҮНИЙН ТААМАГЛАЛ -2015 ОН ХҮРТЭЛ

Metal Expert Consulting компани нь төмрийн хүдэр болон нүүрсний үнийн таамаглалыг гаргадаг бөгөөд 2015 он хүртэлх өөрсдийн шинжээчдийн хийсэн үнийн судалгааг үйлдвэрлэл, олборлолт явуулдаг компаниуд болон санхүүгийн компаниудын гаргасан төмрийн хүдрийн үнийн таамаглалтай харьцуулан үзүүлсэн байна.

2013 оны 2-р сарын эхний хоёр долоо хоногт төмрийн хүдрийн үнэ тогтворжиж (Австрали 62% Fe-нунтаг төмрийн хүдэр-CFR, БНХАУ, 150-155 ам.доллар/тн) байснаа 1-р улирлын 2-р хагасаас зах зээл дээр сөрөг хандлага бий болж үнэ буурч эхэлсэн. Зах зээлийн гол оролцогчид болон мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар БНХАУ-ын гангийн хэрэглээ буурч төмрийн хүдрийн худалдан авалт багассан нь үнэ буурах гол шалтгаан болсон байна.

13-р зураг



Үйлдвэрлэл эрхэлдэг болон санхүүгийн компаниудын гаргасан төмрийн хүдрийн үнийн таамаглал (ам.доллар/тн)



11-р хүснэгт

Эх сурвалж	Үнэ/Таамагласан бүтээгдэхүүний үзүүлэлт	Үнийн таамаг гаргасан он, сар	2012	2013				2013	2014	2015	Удаан хугацааны үнийн таамаглал
				1-р ул.	2-р ул.	3-р ул.	4-р ул.				
HSBS	Австрали-Нунтаг Төм/хүдэр	2013.01	124					123	105	105	80
Goldman Sachs	БНХАУ,CFR 62%Fe-төм/хүдэр	2013.03	130					139	126	90	80
J.P.Morgan	БНХАУ,CIF 62%Fe-төм/хүдэр	2013.01	131	145	130	125	120	130	115	105	80
Standart Bank	Энэтхэгээс БНХАУ-руу нийлүүлэх нунтаг төм/хүдэр	2013.01	127	125	140	133	140	135	125	115	
ABN AMRO	БНХАУ -нунтаг төм/хүдэр	2013.01	138	139				136	119	115	
Deuche Bank	62%CFR-БНХАУ-руу импортлох нунтаг Төм/Хүдэр	2013.01	124					125	115	110	80
ABARE	Австрали-Нунтаг Төм/хүдэр	2013.03	129					119	114	105	96
Morgan Stanley	Австрали-FOB Төм/хүдэр	2013.01	139	142		125		133			110
World Bank	БНХАУ,CFR 62%Fe-нунтаг төм/хүдэр	2013.01	128					130	132	135	150
Westpac	Австрали-Экспортын FOB үнэ	2013.01	120	135	175	175	110	149	150		
Renaissance Capital	БНХАУ,CFR 62%Fe-хуурай нунтаг	2013.04	128	148	125	115	110	125	100	90	90
Citigroup Inc	Австрали-Нунтаг Төм/хүдэр	2013.01	125	135	120	110	115	120	122	122	
KPMG	БНХАУ,CFR 62%Fe-нунтаг төм/хүдэр,Тяньжинь боомт	2012.12	133					130	120	110	90
Macquarie Bank	БНХАУ, 62%Fe-төм/хүдэр-н спот үнэ	2013.01	130	140	140	130	130	130	125	115	80
Credit Suisse	БНХАУ,CFR 62%Fe-нунтаг, хуурай төм/хүдэр	2013.01	128	130	125	115	110	120	100	90	90
CBA	БНХАУ, 62%Fe-төм/хүдэр-н спот үнэ,CFR	2013.01	129					119	116	115	86
Merill Lynch	63.5%Fe-Нунтаг төмрийн хүдэр	2013.01	125	145	124	114	114	124	111		
ANZ	БНХАУ, 62%Fe-төм/хүдэр-н спот үнэ,CFR	2013.03	125	145	135	132	132	136	129	125	
UBS	62%Fe төм/хүдэр	2013.01		130	135	111	111	122			
Morningstar	62%Fe төм/хүдэр	2013.01						130		90	
Masquarie	62%Fe төм/хүдэр	2013.01						140			
BMO	62%Fe	2013.03	128	148	130	115	120	128	125	120	
Зөвшилцөл дээр суурилсан таамаглал	Нунтаг төм./хүдэр, (62%Fe, C-FR,Хятад)		129	144	137	129	121	132	120	109	93
Таамаглал (max)	Нунтаг төм./хүдэр (62%Fe, C-FR,Хятад)		129	144	183	183	132	157	158	135	150
Таамаглал (min)	Нунтаг төм./хүдэр (62%Fe, C-FR,Хятад)		129	144	120	110	114	119	100	90	80




Дээр үзүүлсэн судалгаанаас харахад ихэнх компаниуд цаашид жил ирэх тусам төмрийн хүдрийн үнэ буурна гэсэн таамаглалыг гаргасан байна.

6. МОНГОЛ УЛСЫН ТӨМРИЙН ХҮДЭР ОЛБОРЛОЛТЫН ХЭМЖЭЭ БА НӨӨЦ


2012 оны эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд төмрийн хүдрийн нөөц (A+B+C) 1 тэрбум тн байна гэж улсын ашигт малтмалын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн байна. Нийтдээ 28%-60%-ийн дундаж агуулгатай 46 орд бүртгэгдсэнээс 50 сая тонноос дээш нөөцтэй ордуудад Төмөртэй, Баянгол, Цахиурт-Овоо, Таяннуур, Эрээн, Дарцагтын төмрийн хүдрийн ордууд багтсан байна.

14-р зураг



15-р зураг





16-р зураг

12-р хүснэгт

Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Хүдэр олборлолт /мян.тн/				
		2008	2009	2010	2011	2012
1	Жинхуа орд	22.6	141.8		118.6	318.00
2	Болдтөмөр ерөө гол	1,103.484	1,666.8	2,026.2	3,767.9	3,975.72
3	Анхай-Интернэшнл	66.1	51.27	42.9		54.71
4	Хангихүдэр			4.2	24.2	
5	Тунсинь	226.8	469.7	363.7	743.3	752.70
6	Эрдэсгрупп	180.5	217.3	6.4	19.7	
7	Монголметал майнинг	27.7	106.9	41.1	152.2	119.90
8	Эрвэнхүдэр	33.69	26.2	60.1		
9	Алтайнхүдэр	15	123.0	846.8		4,550.67
10	Эй Эл Жи Ти	27.06				
11	Шинь Шинь	21				
12	Дарханы төмөрлөгийн үйлдвэр		21.3	561.7	1276.6	1235.30
13	Монлаа		47.4	141.1	454.5	255.50
14	Бэрэнгрупп			12.1	90.0	
15	Зө-Юүе			14.3	143.3	
16	Голденпогада				37.0	
17	МГМК			83.7		



8. ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДУУДЫН МЭДЭЭЛЭЛ

1. Төмөртэйн төмрийн хүдрийн орд

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт оршдог. Хүдрийн нөөц В-57 сая тн, С1-100.7 сая тн, С2-71.6 сая тн /1995 он/. Жилд 600000 тн хүчин чадлаар ашиглах боломжтой. Агуулга: Төмрийн агуулга 50-51.6%, Хүхрийн агуулга 1.08-1.4%, Фосфорын агуулга 0.05%. Хүчин чадал: Жилийн хүчин чадал 1 сая тн төмрийн хүдэр олборлоно, баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 620 мян.тн төмрийн баяжмал гаргана. Төмөртэйн орд нь уул техникийн нөхцлийн хувьд ил аргаар ашиглахад тохиромжтой ба хүдрийн биетийн хэсгүүдээс хамааруулан 3 карьер байгуулж, эхний жил 2,0 сая тонн, дараах 2 жилд 4,0 сая тонн, цаашид жилдээ 6.5 сая тн төмрийн хүдэр олборлох уурхай, баяжуулах үйлдвэр барих ба баяжуулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн барих үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөж байна. Ордод хамгийн ойр орших төмөр замын өртөө нь 90 км-т орших Дулаанхааны өртөө ба Дулаанхаан хүртэл сайжруулсан шороон замтай. Цахилгаан хангамжийн хувьд Дархан хотоос Бугантайн үйлдвэр рүү татсан 110 кВт-ын өндөр хүчдэлийн шугам ордоос баруун урагш 15-20 КМ зайд байдаг. Газар доорх усны эрэл хайгуулыг 1990-1991 онд гүйцэтгэж Шувуут, Сөдөтийн голын савд 1728 метр куб/хоногийн газар доорх усны нөөцийн үнэлгээ хийж, үйлдвэрийн ус хангамжийг шийдэх боломжтойг тогтоосон. Монгол, БНХАУ-ын хамтарсан “Төмөртэй хүдэр” ХХК Төмөртэйн ордод 2004 оноос олборлолт явуулж ордын бодит нөөцөөс 461,1 мянган тонн төмрийн хүдэр олборложээ. Хүдэр олборлолтыг ил уурхайн аргаар явуулж байсан ба өрөмдөж тэсэлсэн хүдрийг бага даацын машинаар тээвэрлэн тусгай талбайд асгаж овоолго хийн соронзон ялгагчаар төмрийн өндөр агуулгатай хэсгийг ялгаж, хоосон чулуулгыг туузан дамжлагаар хаягдлын овоолго дээр овоолж байсан.

Үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний нүүрсийг ордоос баруун урагш 90 км-т орших Шарын голын нүүрсний уурхайгаас хангах боломжтой. Төмөртэйн орд нь манай улсын дэд бүтэц сайн хөгжсөн Дархан-Сэлэнгийн районд байрладагаас гадна Баянгол, Төмөртолгой, Хуст уулын төмрийн ордууд 30-40 км зайтай байгаа нь уг ордуудыг багцаар нь ашиглах таатай нөхцлийг бүрдүүлдэг. Уг районд нийтдээ 367,98 сая тонн бодит болон боломжит хүдрийн нөөц тогтоогдоод байна.

1997 оны 6 дугаар сарын 21-д Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг Төмөртэйн төмрийн хүдрийн ордод “БЛТ” ХХК-д 216 га талбай бүхий ашигт малтмал ашиглах 939А тоот тусгай зөвшөөрөл олгосон байна. 939А тоот тусгай зөвшөөрлийг 2005 оны ГУУКГ-ын даргын 302 тоот шийдвэрийг үндэслэн “Төмөртэй хүдэр” (“БЛТ” ХХК, БНХАУ-ын Хэлэмжан (Heilongjiang) мужийн Олон улсын техник эдийн засгийн хамтын ажиллагааны компаниудын хамтарсан компани) ХХК-д шилжүүлэн эзэмшиж байсан.

Ордын тусгай зөвшөөрлийг тус компани 2007 он хүртэл эзэмшсэн ба 2006 онд УИХ-аар шинэчлэн батлагдсан Ашигт Малтмалын хуулийн 4.1.11-д заасны дагуу Төмөртэйн ордыг стратегийн ач холбогдолтой ордод хамааруулан тусгай зөвшөөрлийг нь төрийн мэдэлд шилжүүлсэн.

2. Баргилтын төмрийн хүдрийн орд

Баргилтын төмрийн хүдрийн орд нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт, Улаанбаатар хотоос 280 км, Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрээс 18 км зайд оршдог. 2007 онд стратегийн ордод нэр дэвшүүлсэн 39 ордод багтахдаа Улсын эрдэс баялгийн нөөцөд бүртгэгдээгүй байсан юм. 1984-1987 онд Эрэл геофизикийн цогцолбор



экспедици эрлийн ажил хийх явцдаа төмөр болон дагалдах бусад элементүүд, төмрийн хүдрийн чанарыг ордын хайгуулын үед тавигддаг шаардлагын хэмжээнд бүрэн судлаагүй гэсэн шалтгааны улмаас улсын нэгдсэн бүртгэлд аваагүй байна тухайн үед нөөцийг $C2=31$ сая тооноор тооцож байжээ.

Баргилтын овооны төмрийн хүдрийн илрэлийн үндсэн хэсгийг бүхэлд нь Монгол-Оросын хамтарсан “Монголросцветмет” нэгдэл эзэмшдэг. 2009-2010 онд ордын хайгуулыг хийж, нөөцийг батлуулжээ. Нийт таамагласан нь 43 сая тонн, үүнээс батлагдсан нь 23 сая тонн. ТЭЗҮ хийлгээд, одоо ашиглахаар ажиллаж байна. Соронзон баяжуулах аргаар төмрийн хүдэр үйлдвэрлэх төлөвлөгөөтэй. 2012 оноос бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхэлнэ. Жилдээ хоёр сая тонн төмрийн хүдэр олборлож сая хүртэл тонн баяжмал гаргахаар төлөвлөжээ.

Харин хүдрийн биетийн зүүн хэсэг Y-C, YI-C блокуудад “Голден зеун интернэшнл” ХХК хайгуул явуулж байгаад ашиглалтын тусгай зөвшөөрлөө БНХАУ-ынхөрөнгө оруулалттай “Лут чулуу” компанид шилжүүлсэн байна. 84 га талбайг хамардаг тус компанийн төмрийн хүдрийн уурхай өрөмдлөг-тэсэлгээ-эксковац-тээвэрлэлт-гадаад овоолго гэсэн дамжлагаар, хуурай баяжуулалтын аргаар жилдээ 250 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал боловсруулан экспортолдог байна. Мөн “Цахир цагаан гол” компани энэ орд дээр 1283,75 га газарт хайгуулын тусгай зөвшөөрөл авчээ.

3.Төмөртолгойн төмрийн хүдрийн орд

Монгол Улсын анхны гангийн үйлдвэр болох төрийн өмчит Дарханы төмөрлөгийн үйлдвэр төмрийн хүдрийн гурван орд газрыг эзэмшдэг. Түүний нэг нь Дархан-Уул аймгийн Хонгор суман дахь Төмөртолгойн төмрийн хүдрийн орд юм. Төмөртолгойн орд нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Дархан хотоос зүүн урагш 30 км зайд байрлана. Уг орд нь хатуу хучилттай замаас 15-17 км, Улаанбаатар-Сүхбаатарын төмөр замаас 20-25 км-т, Дархан хотоос Шарын голын нүүрсний уурхай руу явсан төмөр замаас 8-10 км зайд оршдог. Далайн түвшнээс дээш 1057.5 метр өндөрт орших Төмөртолгой хэмээх уулын орой болон бэлийг даган байрладаг байна.

Энэ ордыг Оросын геологич Н.Гилева, В.Малышев, И.Польщук нар 1960 онд судалжээ. Төмөртолгойн орд дахь хүдэр дунджаар 57,19 хувийн төмрийн агуулгатай. Нөөц нь $V+C1=21,3$ сая.тн байна. В.Тараниний тогтоосноор ордыг ил аргаар 800м горизонтоос эхлээд доош 200м хүртэлх гүнд ил аргаар ашиглах боломжтой. Төмөртолгойн төмрийн орд нь хүдрийн 7 биетээс бүрдэх бөгөөд Зүүн, Төв болон Баруун гэсэн 3 хүдрийн биет нь харьцангуй хэмжээ томтой, “Зэрэгцээ” хүдрийн биет нь хэмжээгээр том биш, үлдсэн 3 нь илрэл маягийн биетүүд аж.

Төмөртолгойн ордыг 2005 оноос Дарханы төмөрлөгийн үйлдвэр эзэмшиж байгаа юм.

2009 оны наймдугаар сараас эдийн засгийн эргэлтэд оруулснаар ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Хүдрийн төвийн болон зүүн биетүүд хөрснөөс 1-15 метрийн гүнд байрлах тул ил аргаар олборлолт явуулдаг. Жилд нэг сая тонн хүдэр олборлож, хуурай соронзон аргаар баяжуулаад 650 мянган тонн баяжмал боловсруулж байна. Олборлосон хүдрээсээ урд хөрш рүү гаргаж байгаа.

9. Жишиг үнийн эх сурвалжийн өөрчлөлт

2013 оны 4-р сарын 06-ны өдөр батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 131-



р тогтоолын 2-р заалтаар Засгийн газрын 2007 оны 88-р тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр”-ийн 3,4,6 дахь заалтыг өөрчлөн найруулсны дагуу төмрийн хүдрийн жишиг үнийн сурвалжийг “Австралийн төмрийн хүдэр үйлдвэрлэгчдээс БНХАУ-ынган үйлдвэрлэгчид нийлүүлж байгаа Dampier/Hedland боомтын FOB үнийг /www.umetal.com/ авахаар болсон.

10. Төмрийн хүдрийн үнийн одоогийн байдал ба цаашдын хандлага

Төмрийн хүдэр: 62%-ийн агуулгатай төмрийн хүдрийн дундаж үнэ 2013 оны эхний 9 сарын байдлаар нэмэгдэж 135,51 ам.доллар/тн болсон ба 2012 оны мөн үеийн дундаж үнэ болох 130,66 ам.доллар/тн-той харьцуулахад 3,71%-р нэмэгдсэн.

БНХАУ-ын цагаан сарын баяр хүртэл гангийн үйлдвэрүүд нөөцлөх худалдан авалтаа хийж байсан тул үнэ нэмэгдэж байсан ба энэ баярын дараагаар цаг агаар дулаарч барилга болон үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа идэвхжиж эхлэхээр нийт түүхий эдийн үнэ нэмэгдэнэ гэсэн хүлээлт байсан боловч төмрийн хүдрийн худалдан авалт нэмэгдээгүй хэвээр байсан.

2013 оны 3 сард болсон БНХАУ-ын


Коммунист Намын их чуулганаас 5 шинэ бодлого хэрэгжүүлэхээр болсны дотор үл хөдлөх хөрөнгийн салбарт хэрэгжүүлэх шинэ журам гаргасан нь БНХАУ-ын дотоодын зах зээл дээр төмрийн хүдрийн үнэ буурах гол шалтгаан болсон.


БНХАУ-ын гангийн зах зээл 2013 оны эхний 2 улиралд их сул байсан нь төмрийн хүдрийн үнийн бууралтын гол нөлөө байсан.

Гэвч энэ байдал удаан үргэлжлэлгүй 2013 оны 3-р улирлаас гангийн хэрэглээ нэмэгдсэнээр төмрийн хүдрийн үнэ 5,39%-р нэмэгдсэн.

Одоогийн байдлаар БНХАУ-ын төмрийн хүдрийн зах зээл дээр захиалга бага байгаа нь үнийн бууралтад цаашид нөлөөлж болзошгүй байна. Бүхэллэг болон хорголжин төмрийн хүдэр нь боомтууд дээр хомсдолтой байгаа тул үнэ нь тогтвортой хэвээр байна. Мөн БНХАУ-ын зарим том хотуудын агаарын бохирдлыг бууруулахын тулд ган хайлуулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх тул энэ арга хэмжээ ойрын хугацаанд төмрийн хүдрийн үнийн бууралтад нөлөөлж болзошгүй байна. Ойрын хугацаанд үнэ тогтвортой, дунд ба урт хугацаандаа буурах хандлагатай байна. Хүснэгт 14, 15-д 2013 оны төмрийн хүдрийн үнийн өөрчлөлтийг сараар болон улирлаар, 20-р зурагт 2015 он хүртэлх үнийн таамаглалыг үзүүлээ.

19-р зураг





14-р хүснэгт

2013он	Дундаж үнэ	Харьцуулалт	Өөрчлөлт
I улирал	148.29		
II улирал	125.73	III/I	-15%
III улирал	132.51	III/II	5.39%

15-р хүснэгт

2013он	62% агуулгатай төмрийн хүдрийн дундаж үнэ	Харьцуулалт	Өөрчлөлт
I сар	150.49		
II сар	154.64	III/I	3%
III сар	139.84	III/II	-9.57%
IV сар	137.39	IV/III	-1.75%
V сар	123.97	V/IV	-9.77%
VI сар	114.82	VI/V	-7.38%
VII сар	127.19	VII/VI	10.77%
VIII сар	136.87	VIII/VII	7.61%
IX сар	133.83	IX/VIII	-2.22%

Дүгнэлт:

Монгол улсын төмрийн хүдрийн нөөц нь бусад улс орны нөөцтэй харьцуулахад харьцангуй бага тул зөв зохистой ашиглаж, борлуулж буй төмрийн хүдэр, баяжмалын бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр борлуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эх орныхоо дэд бүтэц болон барилгын салбарт хэрэглэх нь нэн чухал байна.

Монгол улсад төмрийн хүдрийн олборлолт явуулдаг компаниудын борлуулалтын гэрээний үнэ нь 36-53 ам.доллар/тн-н хооронд байгаа бөгөөд үүнийг БНХАУ-д төмрийн хүдэр экспортлодог бусад улс орнуудын борлуулж буй үнэтэй харьцуулахад нилээд доогуур байдаг. БНХАУ нь төмрийн хүдрийн нөөцөөрөө дээгүүрт ордог хэдий ч 2010-2011 оны хооронд төмрийн хүдрийн 31 төслийг асар их хөрөнгө зарж бусад улс орнуудаас худалдан авснаас харахад манай урьд хөршид төмрийн хүдрийн хэрэглээ маш их байгааг үзүүлж байна. Иймд борлуулалтын гэрээний үнийг нэмэгдүүлэхийн тулд компаниуд төмрийн хүдрийг баяжуулж агуулгыг нэмэгдүүлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах гангийн үйлдвэрээ зөв сонгох тал дээр анхаарах хэрэгтэй байна.

Одоогийн байдлаар манай өмнөд хөрш рүү Австрали, Бразил, Канад, Чили, Энэтхэг, Индонези, Иран, Малайз, Мавритани, Мексик, Филлифин, Орос, Sierra Leone, Өмнөд Африк, АНУ, Украин, Венесуэл гэсэн 17 орон төмрийн хүдрийг тодорхой агуулга, бүтээгдэхүүний ангилал болон үнийн ялгаатайгаар экспортлож байгаа бөгөөд доорх хүснэгтэд Хятад улс руу төмрийн хүдрээ экспортоор нийлүүлж буй 5 улсын мэдээллийг 2013 оны 11 сарын 07-ны байдлаар үзүүллээ. Иймд Монгол улсын хувьд эдгээр улсуудтай өрсөлдөх чадварыг төмрийн хүдрийн зах зээл дээр бий болгох шаардлага үүсч байна.



16-р хүснэгт


Улс	Бүтээгдэхүүн	Агуулга %	Ачих боомт	Чанар	Буулгах боомт	ҮНБ (CFR) \$/mt	ҮНБ (FOB) \$/mt	Өөрчлөлт \$
Австрали	PB-нунтаг TX	61.5	Dampier/Hedland	чийгшил8%	China- боомт	136	128	+1
	Newman-нунтаг TX	63		чийгшил8%	China- боомт	137	129	+1
	MAC-нунтаг TX	61.5		чийгшил8%	China- боомт	135	127	+1
	Yandi-Нунтаг TX	58		чийгшил3%	China- боомт	125	117	+1
	Robe River-Нунтаг TX	56		чийгшил3%	China- боомт	123	115	+1
	PB-бүхэллэг TX	62		чийгшил 3%	China- боомт	152	144	+1
	Newman-бүхэллэг TX	63		чийгшил3%	China- боомт	153	145	+1
	MAC-бүхэллэг TX	62		чийгшил8%	China- боомт	151	143	+1
	Yandi-Бүхэллэг TX	58		чийгшил8%	China- боомт	137	129	+1
Бразил	SFCJ-Carajas-нунтаг	66	Tubarao/PDM	чийгшил8%	China- боомт	149	129	+2
	SSFT-Southern system Fines	65		чийгшил8%	China- боомт	142	122	+2
	SFOT- бүхэллэг TX	63		чийгшил3%	China- боомт	139	119	+3
	Хорголжин TX	65		чийгшил3%	China- боомт	156	136	+1
		66		чийгшил3%	China- боомт	174	154	+1
Энэтхэг	нунтаг TX	63.5/63	Chennai/Paradip	чийгшил8%	India-боомт	137	123	
	нунтаг TX	63/62	Chennai/Paradip	чийгшил8%	India-боомт	136	122	
	нунтаг TX	61/60	Chennai/Paradip	чийгшил8%	India-боомт	130	116	
	нунтаг TX	62/61	Chennai/Paradip	чийгшил8%	India-боомт	132	119	
	нунтаг TX	60/59	Chennai/Paradip	чийгшил8%	India-боомт	127	113	
	нунтаг TX	59/58	Goa/Mangalore	чийгшил8%	India-боомт	122	108	
	нунтаг TX	58/57	Goa/Mangalore	чийгшил8%	India-China боомт	118	104	
	нунтаг TX	55/54	Goa	чийгшил8%	India-боомт	106	92	
	нунтаг TX	53/52	Goa	чийгшил8%	India-боомт	88	74	
Иран	Гематит	62/61	Banda abbas	Si-6%		122	97	
	Гематит	61/60		Al-2%		119	94	
	Гематит	60/59		P-0,2%		115	90	
	Гематит	59/58		S-0,2%		112	87	
	Магнетит	62/61		By bulk		124	99	
	Магнетит	61/60				121	96	
	Магнетит	60/59				117	92	
	Магнетит	59/58				114	89	
Орос	TX-ийн баяжмал	67	Black sea	чийгшил8%	China- боомт	151	131	+1
	TX-ийн баяжмал	65	Black sea	чийгшил8%	China- боомт	148	128	+1
	TX-ийн баяжмал	63.5	Murmansk	чийгшил8%	China- боомт	142	122	+1
	Хорголжин TX	63	Black sea	чийгшил8%	China- боомт	166	146	+1
	Хорголжин TX	65	Black sea	чийгшил8%	China- боомт	175	157	+1



2012-2016 онд олборлолтоо эхлүүлэх болон өргөтгөлийн ажил хийгдэх төмрийн хүдрийн уурхайн мэдээллийг 6-р зурагт үзүүлсэн бөгөөд энэ мэдээлэлд 2013, 2014 онд төмрийн хүдэр шинээр олборлож эхлэх уурхайн тоо нэмэгдэж 2015, 2016 онуудад огцом буурна гэж үзүүлсэн. Иймд Монгол улс төмрийн хүдрийн ордуудаа ашиглахдаа нэн тэргүүнд ашиглах болон нөөцөлж үлдээх ордууд гэж ангилах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн төмрийн хүдрийн уурхайнууд олборлолт явуулахдаа байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай орчин үеийн шилдэг техник технологи ашиглах, ордыг ТЭЗҮ-ийн дагуу хаягдалгүй бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэй байна.

20-р зураг



11. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ :

1. www.metaleconomics.com
2. www.metalprices.com
3. www.usgs.commodity
4. www.asianmetal.com
5. www.steelindex.com
6. www.umetal.com

